

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

| Д/д   | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин   | Зорилтот түвшин   | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/  | Гүйцэтгэлийн хувь |
|---|--|-------|--|--|---|--|-------------------|
| <b>1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 1: Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.</b>   |  |       |  |  |   |  |                   |
| <b>1.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2-т заасан Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.</b> |  |       |  |  |   |  |                   |
| 1.1.1   | Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | -     | -Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь. | Дорноговь аймгийн 23 гэрээ бүхий ЭМБ-д чанар төлбөрийн хяналтын дүгнэлтийг танилцуулан мэдээлэл ёгсан. | Цахим өгөгдөл хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | Тайлант хугацаанд нийт 61 ЭМБ-ын 136388 тохиолдлын 16,1 тэрбум төгрөгийн тусlamж, үйлчилгээнд чанар, төлбөрийн хяналтыг хийж гүйцэтгэсэн. Үүнээс:<br>-ЭМДҮЗ-ийн 2024 оны 06, 2025 оны 04 дүгээр тогтоолын хүрээнд лавлагаа шатлалын 6, ӨСЭМТ-ийн 13 ЭМБ-ын 2013 тохиолдолд 2388,9 сая төгрөг,<br>-ЭМДҮЗ-ийн 2024 оны 05, 2025 оны 03 дугаар тогтоолын хүрээнд 233 тохиолдолд 86,3 сая төгрөг,<br>-ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын хүрээнд 266,9 мянган төгрөг цахим шүүлтүүр болон эмч байцаагчийн нарийвчилсан хяналтаар хасаж тооцсон.<br>Нийт 2036 тохиолдлын 2475,2 сая төгрөгийн хасалт хийгдсэн байна.<br>Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр гэрээт лавлагаа шатлалын 6, анхан шатны 17 эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилт болон ЭМДҮЗ-ийн тогтоол, шийдвэрүүдийг танилцуулж, зөвлөгөө мэдээллээр ханган, эмч ажилтнуудыг | 100               |

|       |  |   |   |  |   |   |     |
|-------|--|---|---|--|---|---|-----|
|       |  |   |   |  |   | чадавхжуулах 2 удаагийн сургалтыг танхимаар зохион байгууллаа.<br>Улсын байцаагчийн зөвлөмжийг 18 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж ажилласан.  |     |
| 1.1.2 | Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023, 2024 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна. | - | Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо                                       | Гэрээт 61 ЭМБ-ыг холбогдох тоон мэдээллээр хангасан. | Статистик мэдээллийг олон олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээ зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023, 2024 оны ЭМД-ын сангийн орлого, хамрагдалт болон санхүүжилтийн зардлын мэдээг ЭМДЕГ, АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, ЭМГ, Статистикийн хэлтэст тус бүр 4 удаа хүргүүлж, ЭМДС-ийн Статистик тоон мэдээллээр ханган ажилласан.<br>Гэрээт 61 ЭМБ-ыг холбогдох тоон мэдээллээр хангасан. Мөн ЭМД-тай холбоотой статистик мэдээллийг 200 гаруй иргэнд түгээн сурталчилсан.  | 100 |
| 1.1.3 | "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн шинэчлэн батлагдсан тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.  | - | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо - Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо | ЭМДҮЗ-ийн 2024 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажилласан байна.                         | -ЭМДҮЗ-ийн 04, 10 дугаар тогтоолыг шинэчлэх ажлын хүрээнд тогтоолын төслийг гэрээт лавлагаа шатлалын 6 ЭМБ, 13 СЭМТ-д хүргүүлсэн.<br>БТГ-аас зохион байгуулсан тогтоолын шинэчлэлтэй холбоотой нийт 5 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт аймгийн ЭМГ болон лавлаггаа, анхан шатны ЭМБ-уудыг товлосон хугацаанд шат дараатайгаар хамруулсан.<br>Уг сургалтад 19 ЭМБ-ын удирдлага, 86 эмч, мэргэжилтэн цахимаар хамрагдсан.<br>-Хэлтсээс ЭМДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолын шинэчлэлтэй холбоотой 2 удаагийн сургалтыг танхимаар зохион байгуулсан. Сургалтад 30 эрүүл мэндийн байгууллагын 34 удирдах ажилтан, эмч, мэргэжилтэн хамрагдсан.<br><b>Үр дүн:</b> ЭМДҮЗ-ийн 2025 оны 04, дүгээр тогтоолыг гэрээт лавлагаа шатлалын 6, анхан шатны 13, нийт 19 ЭМБ-д хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. | 100 |
| 1.1.4 | "ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх   | - | -Журмыг хүргүүлж  | ЭМДҮЗ 2024 оны 05 дугаар                             | Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад   | -ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоолыг шинэчлэх ажлын хүрээнд тогтоолын журмын төсөл, шийдвэрүүдийг танилцуулах чиглэл хүргүүлэх 2 удаагийн албан бичгийг гэрээт 17 ΘСЭМТ-д   | 100 |

|       |   |   |  |   |  |  |     |
|-------|---|---|--|---|--|--|-----|
|       | эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах" тухай ЭМДҮЗ-ийн шинэчлэн батлагдсан тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.              |   | танилцуулсан ЭМБ-ын тоо<br>-Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо  | тогтоолыг мөрдөж байна.                                     | танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна.   | хүргүүлсэн. Мөн БТГ-аас зохион байгуулсан тогтоолын шинэчлэлтэй холбоотой нийт 2 удаагийн сургалтад ЭМГ болон 17 ӨСЭМТ-ийн удирдлага, 56 эмч, мэргэжилтэн цахимаар хамруулсан. Хэлтсийн зүгээс ӨСЭМТ-ийн эмч нарт 03 дугаар тогтоолын шинэчлэлтэй холбоотой 2 удаагийн сургалтыг танхимаар зохион байгууллаа. Нийт 29 эмч мэргэжилтэн хамрагдсан.<br><b>Үр дүн:</b> ЭМДҮЗ-ийн 2025 оны 03 дугаар тогтоолыг гэрээт анхан шатны 17 ЭМБ-д хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. |     |
| 1.1.5 | Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана.                      | - | ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна. 2024 онд 2362 иргэн хамрагдаж 384,2 сая төгрөгийн санхүүжилт олгосон. | -Санхүүжүүлсэн мөнгөн дүн<br>-Хамрагдсан даатгуулагчийн тоо | Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-удын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна. | ЭМДҮЗ-ийн 2025 оны 10 дугаар тогтоолын дагуу "Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдсан 894 иргэний 153,2 сая төгрөгийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.<br><b>Үр дүн:</b> УСЭИ үзлэгт хамрагдсан 891 даатгуулагч иргэний тусламж, үйлчилгээний зардал болох 152,6 сая төгрөгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг лавлагаа шатлалын 2 ЭМБ-д олгохоор тооцсон.                      | 100 |
| 1.1.6 | ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин эүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого | - | Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт 2 санал хүргүүлсэн саналын тоо                                    | Бодлого төлөвлөлтийн газарт 2 санал хүргүүлсэн              | Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.                             | -ЭМДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилт болон ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, ЭМБ-ын санал бодлыг хүлээн авч зарим архаг ОХБ-ийг цочмог ОХБ-т оруулахтай холбоотой саналыг БТГ-т хүргүүлсэн.<br><b>Үр дүн:</b> Хүргүүлсэн саналын тоо-2   | 100 |

|       |  |   |   |   |   |   |     |
|-------|--|---|---|---|---|---|-----|
|       | төлөвлөлтийн газарт хүргүүлнэ.   |   |   |   |   |   |     |
| 1.1.7 | "ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ"-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана. | - | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо<br>-Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо | - | Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг холбогдох нэгжид тайлагнасан байна. | ЭМДҮЗ-ийн 2025 оны 03 дугаар хуралдаанаар баталсан "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 11 дүгээр тогтоолыг гэрээт 38 эмийн санд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. | 100 |

1.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4-т заасан "Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно" зорилтын хүрээнд:

|       |  |   |                         |  |  |   |     |
|-------|--|---|-------------------------|--|--|---|-----|
|       | Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2.1.3, БГТ-1.4.3 Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө. | - | -Хүргүүлсэн саналын тоо | Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад 3 удаа санал хүргүүлсэн. | Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна. | -ЭМДҮЗ-ийн 03, 04 дүгээр тогтоолыг шинэчлэн боловсруулах төсөлд санал авах хүсэлтийг ЭМГ, лавлагаа шатлалын 4 эмнэлэг, 17 θCЭМТ-д хүргүүлэн тусlamж үйлчилгээтэй холбогдох саналыг хүргүүлсэн.<br>-Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, цуглуулах, төвлөрүүлэх журам"-ын төсөлд;<br>-ЭМДЕГ, ХХҮЕГ-ын 2025 онд "Хамтран ажиллах гэрээ"-ний төсөлд;<br>-Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журам"-ын төсөл;<br>-Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчлэн найруулах хуулийн төсөлд тус тус саналыг хүргүүлэн ажилласан.<br><b>Үр дүн:</b> Хүргүүлсэн саналын тоо: 5 | 100 |
| 1.2.2 | Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд  | - | Зөрчлийн хэргийн тоо    | 2024 оны аймгийн Прокурорын байгууллагатай хамтран гэмт  | Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль                          | Хууль хяналтын байгууллагатай хамтран гэмт хэргийн улмаас төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөнөөс ЭМДС-д үүссэн хохирлыг барагдуулах ажлын хүрээнд дараах  | 100 |

|  |  |  |   |                                     |  |  |
|--|--|--|---|-------------------------------------|--|--|
|  | зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамtran ажиллана. |  | хэрэгт холбогдсон 154 хүний судалгааг гарган өгч 54 хүнийг шүүхийн байгууллагад шилжүүлсэн. Санд 86,6 сая төвлөрүүлсэн. | тогтоомжийн хүрээнд явуулсан байна. | байгууллагуудад лавлагаа мэдээллийг гарган хүргүүллээ. Үүнд:<br>- Аймгийн прокурорын байгууллага 7 хаваст хэрэгт холбогдох 17,0 сая төгрөгийн лавлагаа;<br>- Цагдаагийн байгууллагад 51 хүний 75,6 сая төгрөгийн лавлагаа;<br>-Анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагчид 13 хүний 3,1 сая төгрөгийн лавлагаа мэдээллийг тус тус гарган хүргүүлсэн байна.<br>Мөн ШШГТ-т 51 иргэний 1,2 сая төгрөгийн лавлагаа мэдээллийг гарган хүргүүлсэн.<br><b>Үр дүн:</b> ЭМДС-д 99,3 сая төгрөгийг төвлөрүүлсэн. |  |
|--|--|--|---|-------------------------------------|--|--|

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусlamж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.

2.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1-т заасан “Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусlamж, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд:

| 2.1.1  | ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГУАХ 2.1.7. БГТ 2.1.1<br>Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл зохион ажиллагааг байгуулна. | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 47,1 | 2025 онд 70 хувиас дээш хамруулна. | <p>ЭМДЕГ-ын даргын 2025 оны А/12 тоот тушаалаар баталсан “Малчид, оюутан суралцагчид, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМД-ын хамралтын төлөвлөгөө”-ний биелэлтийг дүгнэж үзэхэд: Тайлант хугацаанд 2723 иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулахаар төлөвлөгдсөнөөс 3134 иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулж 115%-ийн биелэлтэй ажилласан.</p> <p><b>Эрүүл мэндийн даатгалын хамралт</b><br/>(2025.01.01-2025.04.30 байдлаар)</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>Үзүүлэлтийнн эр</th><th>Төлөв-лөгөө</th><th>Гүйцэт гэл</th><th>Хувь</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td>АХЭ-гүй иргэн</td><td>1550</td><td>1197</td><td>77%</td></tr> <tr> <td>2</td><td>Оюутан</td><td>314</td><td>1144</td><td>364%</td></tr> <tr> <td>3</td><td>Малчин</td><td>851</td><td>782</td><td>92%</td></tr> <tr> <td>4</td><td>Гадаадын иргэн, харьгүй хүн</td><td>8</td><td>11</td><td>137%</td></tr> </tbody> </table> | № | Үзүүлэлтийнн эр | Төлөв-лөгөө | Гүйцэт гэл | Хувь | 1 | АХЭ-гүй иргэн | 1550 | 1197 | 77% | 2 | Оюутан | 314 | 1144 | 364% | 3 | Малчин | 851 | 782 | 92% | 4 | Гадаадын иргэн, харьгүй хүн | 8 | 11 | 137% | 100 |
|--|--|--|---------------------------------|------------------------------------|---|---|-----------------|-------------|------------|------|---|---------------|------|------|-----|---|--------|-----|------|------|---|--------|-----|-----|-----|---|-----------------------------|---|----|------|-----|
| №  | Үзүүлэлтийнн эр  | Төлөв-лөгөө                                      | Гүйцэт гэл                      | Хувь                               |   |   |                 |             |            |      |   |               |      |      |     |   |        |     |      |      |   |        |     |     |     |   |                             |   |    |      |     |
| 1  | АХЭ-гүй иргэн  | 1550   | 1197                            | 77%                                |   |   |                 |             |            |      |   |               |      |      |     |   |        |     |      |      |   |        |     |     |     |   |                             |   |    |      |     |
| 2  | Оюутан   | 314  | 1144                            | 364%                               |   |   |                 |             |            |      |   |               |      |      |     |   |        |     |      |      |   |        |     |     |     |   |                             |   |    |      |     |
| 3  | Малчин   | 851  | 782                             | 92%                                |   |   |                 |             |            |      |   |               |      |      |     |   |        |     |      |      |   |        |     |     |     |   |                             |   |    |      |     |
| 4  | Гадаадын иргэн, харьгүй хүн  | 8  | 11                              | 137%                               |   |   |                 |             |            |      |   |               |      |      |     |   |        |     |      |      |   |        |     |     |     |   |                             |   |    |      |     |
| Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 100                    | 2025 онд 100 хувиас дээш хамруулна.  |  |                                 |                                    |   |   |                 |             |            |      |   |               |      |      |     |   |        |     |      |      |   |        |     |     |     |   |                             |   |    |      |     |
| Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 43,8  |  |                                 |                                    |   |   |                 |             |            |      |   |               |      |      |     |   |        |     |      |      |   |        |     |     |     |   |                             |   |    |      |     |
|  | 2025 онд 70 хувиас дээш хамруулна.   |  |                                 |                                    |   |   |                 |             |            |      |   |               |      |      |     |   |        |     |      |      |   |        |     |     |     |   |                             |   |    |      |     |

|       |  |   |                                    |   |  | дүн   | 2723 | 3134 | 115% |  |  |
|-------|--|---|------------------------------------|---|--|---|------|------|------|--|--|
|       |  |   |                                    |   |  | Сумдын Засаг дарга нарт ЭМД-ын хамралтыг нэмэгдүүлэх, малчин, ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлүүлэх, хамтран ажиллах тухай албан бичгийг хүргүүлэн ажиллалаа.  |      |      |      |  |  |
|       |  |   | Байгууллага, аж ахуйн нэгжийн хувь | 2024 оны хамрагдалтын хувь 100  | 2025 онд 100 хувь хамруулна.   | 14 sumaас малчин, ажилгүй иргэдийн судалгааг авч, health программаар ЭМД-ын шимтгэл төлөлтийг нэг бүрчлэн шалгахад хамрагдалт 92%-ийн биелэлттэй байна.   |      |      |      |  |  |
| 2.1.2 | Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ.   | - | Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо  | 2024 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, тайлан мэдээг гарган жилд 4 удаа ЭМДЕГ-т хүргүүлсэн. | Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган 4 удаа хүргүүлсэн байна.        | Тайлант хугацаанд гэрээт 61 ЭМБ-аас тусламж, үйлчилгээ авсан 134074 /давхардсан тоогоор/ даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардалд 18,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. ЭМД-ын сангийн зардлын сарын мэдээг 2025 оны 1-3 сарын байдлаар батлагдсан маягтын дагуу үнэн зөв бодит тоон мэдээнд үндэслэн гаргаж, аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Статистикийн хэлтэст хугацаанд нь гаргаж, хүргүүлэн ажилласан. ЭМДС-ын 1 дүгээр улирлын санхүүгийн тайланг гаргаж, ЭМДЕГ-ын Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн. | 100  |      |      |  |  |
| 2.1.3 | ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖУЧ-2.2.5, МУЗГУАХ 2.1.7, Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуйж, тайлагнана. | - | Төвлөрүүлсэн мөнгөн дүн            | 2024 онд орлогын төлөвлөгөөний биелэлт 86 хувьтай.  | ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 88 хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | ЭМДҮЗ-ийн 2025 оны 01 дүгээр тогтооолоор батлагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын 2025 оны төсвийн хуваарь”-ийн дагуу сангийн орлогын хамрагдалтын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр Нийгмийн даатгалын газар, сумдын Засаг дарга нартай хамтран ажиллаж байна.<br>-Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлого 7472,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 5851,2 сая төгрөгийг төвлөрүүлж, биелэлт 78,3%,<br>-Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, оюутан, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэдээс 352,0 сая   | 80   |      |      |  |  |

|  |  |  |  |  |  |   |  |
|--|--|--|--|--|--|---|--|
|  |  |  |  |  |  | төгрөгийг төвлөрүүлэхээс 376,9 сая төгрөг төвлөрүүлж 107%-аар тус тус биелэлттэй ажилласан. Нийт 7824,0 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 6228,1 сая төгрөгийг ЭМД-ын санд төвлөрүүлж 80 %-ийн гүйцэтгэлтэй байна. |  |
|--|--|--|--|--|--|---|--|

2.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2-т заасан "Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална" зорилтын хурээнд:

|       |  |   |   |  |   |  |            |
|-------|--|---|---|--|---|--|------------|
| 2.2.1 | <i>Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2.2.1, БГТ-2.2.1<br/>Өглөг, авлагын үүсгэхгүй ажилана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.</i> | - | <i>-Өглөг, авлагын тоо хэмжээ -Тайлан</i> | <i>2024 онд 3,4 тэр бум төгрөгийн өглөгтэй тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн.</i> | <i>Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна.</i> | <i>Санхүү бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэнтэй сар бүр тооцоо нийлж ажиллаж байна. Өмнөх оны 3,4 тэр бум төгрөгийн өглөг, 63,8 сая төгрөгийн авлагыг барагдуулсан.</i> | <i>100</i> |
|-------|--|---|---|--|---|--|------------|

3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 3: Тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна

3.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1-т заасан "Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна" зорилтын хурээнд:

| 3.1.1               | <i>Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 3.1.2, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.1<br/>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангудын 2024 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна.</i> | -                        | <i>Гэрээ дүгнүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо</i> | <i>2024 онд 61 гэрээт ЭМБ-ыг дүгнэсэн</i> | <i>Гэрээт ЭМБ-уудын гэрээг хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна.</i> | <i>ЭМДЕГ-ын даргын 2024 оны А/175 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ худалдан авах гэрээ дүгнэх, ажлыг тус хэлтсийн дарга болон чанар төлбөрийн хяналтын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэсэн. Гэрээт лавлагаа шатлалын 6 эмнэлэг, 37 эмийн сан, 17 ӨСЭМТ нийт 61 ЭМБ-ын 2024 оны гэрээг батлагдсан журмын дагуу үнэлж дүгнэсэн. Хангалтгүй үнэлэгдсэн 7 СЭМТ-д улсын ахлах байцаагчийн зөвлөмж, 4 эмийн санд улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг тус тус хүргүүлсэн.</i> | <i>100</i>          |                   |                          |               |   |       |                |   |       |       |    |       |          |
|---------------------|--|--------------------------|--|---|---|---|---------------------|-------------------|--------------------------|---------------|---|-------|----------------|---|-------|-------|----|-------|----------|
|                     |  |                          | <i>Гэрээний хэрэгжилтийн хувь</i>                      | <i>2024 онд гэрээний хэрэгжилт 80,0</i>   | <i>Гэрээний хэрэгжилтийн хувь 90 хувиас доошгүй байна.</i>  | <table border="1"> <thead> <tr> <th><b>ЭМБ-ын төрөл</b></th> <th><b>ЭМБ-ын тоо</b></th> <th><b>Биелэлтийн дундаж</b></th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Улсын эмнэлэг</td> <td>4</td> <td>82,4%</td> </tr> <tr> <td>Хувийн эмнэлэг</td> <td>2</td> <td>74,5%</td> </tr> <tr> <td>ӨСЭМТ</td> <td>17</td> <td>75,1%</td> </tr> <tr> <td>Эмийнсан</td> <td>37</td> <td>87,4%</td> </tr> </tbody> </table>  | <b>ЭМБ-ын төрөл</b> | <b>ЭМБ-ын тоо</b> | <b>Биелэлтийн дундаж</b> | Улсын эмнэлэг | 4 | 82,4% | Хувийн эмнэлэг | 2 | 74,5% | ӨСЭМТ | 17 | 75,1% | Эмийнсан |
| <b>ЭМБ-ын төрөл</b> | <b>ЭМБ-ын тоо</b>  | <b>Биелэлтийн дундаж</b> |  |   |   |   |                     |                   |                          |               |   |       |                |   |       |       |    |       |          |
| Улсын эмнэлэг       | 4  | 82,4%                    |  |   |   |   |                     |                   |                          |               |   |       |                |   |       |       |    |       |          |
| Хувийн эмнэлэг      | 2  | 74,5%                    |  |   |   |   |                     |                   |                          |               |   |       |                |   |       |       |    |       |          |
| ӨСЭМТ               | 17   | 75,1%                    |  |   |   |   |                     |                   |                          |               |   |       |                |   |       |       |    |       |          |
| Эмийнсан            | 37   | 87,4%                    |  |   |   |   |                     |                   |                          |               |   |       |                |   |       |       |    |       |          |

|  |   |   |   |   |  |  |     |
|--|---|---|---|---|--|--|-----|
|  |   |   |   |   |  | Аймгийн хэмжээнд гэрээт 61 ЭМБ-ын гэрээний хэрэгжилт 80%-тай дүгнэгдсэн.   |     |
| 3.1.2  | 2025 онд Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Шинэчлэн байгуулсан гэрээний тоо                    | Өрхийн ЭМТ-4, Сумын ЭМТ-13, Эмийн сан-34  | Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн, шинээр хүсэлт ирүүлсэн ЭМБ-уудтай гэрээ байгуулагдсан байна.  | Лавлагаа шатлалын-6, ӨЭМТ-4, СЭМТ-13, эмийн сан-37 нийт 60 ЭМБ-тай тусlamж үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, гэрээг баталгаажуулан ХАГГ-т хүргүүлэн ажилласан.  | 100 |
| 3.1.3  | Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг ажиллана.  | - | Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо, хэрэгжилтийн тайлан | Гэрээт 61 эрүүл мэндийн байгууллагыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг тайлагнасан. | Журамд орсон өөрчлөлтийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, гэрээт хувийн хэвшлийн эмнэлэг, анхан шатны ЭМБ-уудад танилцуулж, хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна. | 2025 оны А/30 дугаар тушаалын "Журам шинэчлэн батлах тухай" журамд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллээр лавлагаа шатлалын төрийн өмчтэй 4 ЭМБ, гэрээт хувийн хэвшлийн 2 эмнэлэг, анхан шатны 17 ӨСЭМТ, удирдлага болон эмч мэргэжилтэнд танилцуулсан.<br><br>Үр дүн: Гэрээт 23 эрүүл мэндийн байгууллагыг мэдээллээр хангасан. | 100 |
| 3.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2-т заасан "Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусlamж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна" зорилтын хүрээнд: |   |   |   |   |  |  |     |
| 3.2.1  | БГТ-3.2.1<br>Олон улсын эмнэлзүйн удирдамжид сууриссан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн  | - | Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн          | Нийт 61 ЭМБ-д 34,1 тэр бум төгрөгийн нэхэмжлэлийн                                 | Хуваарилагдсан түүвэрт нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг  | Тайлант хугацаанд улсын хэмжээнд гэрээт 131 лавлагаа шатлалын ЭМБ-д нэхэмжлэлийн хяналтыг хийсэн ба хэвтэн эмчлүүлэх, яаралтай, ӨӨОШ, түргэн тусlamжийн 7849 тохиолдлын түүврийн хяналтыг хийж гүйцэтгэсэн. Тус  | 100 |

|       |   |   |  |  |   |   |     |
|-------|---|---|--|--|---|---|-----|
|       | байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.  |   | даатгуулагчийн тоо, мөнгөн дүн                         | гүйцэтгэл хянагдсан.                                       | хугацаанд нь журмын дагуу хэрэгжүүлсэн байна.   | хяналтаар 249,6 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж хасалтыг хийсэн байна.<br>-Аймгийн хэмжээнд лавлагаа шатлалын 2007 иргэний 2387,6 сая төгрөг, ӨСЭМТ-ийн 301 иргэний 271,6 сая төгрөг, нийт 23 ЭМБ-ын 2308 иргэний тусlamж үйлчилгээний зардалд нэхэмжлэлийн хяналтыг хийж 2659,2 сая төгрөгийн хасалтыг баталгаажуулсан.<br><b>Үр дүн:</b> Гүйцэтгэл ирүүлсэн 191 ЭМБ-ын 93762 даатгуулагчийн нэхэмжлэлд хяналтыг хийн 2908,8 сая төгрөгийг хасаж тооцсон.   |     |
| 3.2.2 | БГТ-3.2.3<br>Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.   | - | Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо      | 2024 онд 61 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.        | Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.                         | Гэрээт лавлагаа шатлалын-6, анхан шатны-17, 37 эмийн сан, нийт 60 эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр тухай бүр ханган ажиллаж байна.<br>Мөн анхан шатны 17 ЭМБ-ын эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах эмнэл зүйн сургалтад оролцож ЭМДҮЗ-ийн 03, 04, 10, 11-р тогтоолын шинэчлэлийн талаар мэдээ, мэдээллийг олгон зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.<br>ЭМДҮЗ-ийн 2025 оны 03, 04 дүгээр тогтоолуудыг танилцуулах, мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалтыг танхимаар 2 удаа зохион байгуулсан.<br><b>Үр дүн:</b> Нийт 60 ЭМБ-д зөвлөн туслах, мэдээлэл хүргэх 2 удаагийн танхимиын сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| 3.2.3 | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусlamж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангулна. | - | Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 2024 онд нийт 51 ЭМБ улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн. | Тусlamж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайлант холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусlamж, үйлчилгээний нэхэмжлэлд нарийвчилсан хяналтыг хийж, нэхэмжлэлийн хяналтын шаардлагыг хангаагүй тохиолдлыг шүүж, лавлагаа шатлалын 5 эмнэлэг, 13 ӨСЭМТ-д улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэн ажилласан.<br><b>Үр дүн:</b> Нийт 18 ЭМБ-д зөвлөмж хүргүүллээ.  | 100 |
| 3.2.4 | Байгууллагын 2023-2026 оны стратеги   | - | Хяналт шалгалтад                                       | 2024 онд гэрээт 5  | Газар дээрх хяналт,   | Тайлант хугацаанд иргэний хэргийн Анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагчтай хамтран ЭМДС-  | 100 |

|  |   |        |  |   |  |  |  |
|--|---|--------|--|---|--|--|--|
|  | төлөвлөгөөний<br>БГТ-3.2.2<br>Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ. | 3.2.3, | хамрагдсан байгууллагын тоо -Хяналт шалгалтын тайлан | байгууллагад газар дээрхи хяналт шалгалтыг зохион байгуулсан. | шалгалт хийж, тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | ийн хохирлыг барагдуулах арга хэмжээний хүрээнд гэм буруутай этгээдээс гаргуулах зардлын мөнгийг иргэн болон ЭМД-аас давхар нэхэмжилсэн тохиолдлыг газар дээрх хяналт шалгалтаар илрүүлэн 3,4 сая төгрөгийг аймгийн Нэгдсэн эмнэлгээс гаргуулах албан бичгийг хүргүүлэн ажилласан.<br>Нэхэмжлэлийн хяналтаар илрүүлсэн зөрчил болон иргээдээс ирүүлсэн гомдол санал байхгүй байна. |  |
|--|---|--------|--|---|--|--|--|

4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.

4.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1-т заасан "Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө" зорилтын хүрээнд:

|       |  |   |  |  |   |  |     |
|-------|--|---|--|--|---|--|-----|
| 4.1.1 | ЗГУАХ-2.1.9,<br>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.3<br>Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутгатай хамтарч хэрэгжүүлнэ. | - | -Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо.<br>-Тайлан | 2024 онд 3 удаагийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. | Орон нутгийн удирдлагатай хамтран арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. | Аймгийн Засаг даргатай 2025 онд төлөлөн гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээ байгуулсан. Нутгийн захиргааны байгууллага болон бусад агентлаг, газруудтай 10 удаагийн арга хэмжээнд хамтран оролцож, иргэд, даатгуулагч, олон нийтэд хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг танилцуулан, ЭМД-ын ач холбогдол, ЭМД-аар хөнгөлөлттэй үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг танилцуулан, ЭМД-ын хамралтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан. Үүнд: АЗДТГ-аас зохион байгуулсан -“Малчдын зөвлөгөөн”-д 1 удаа,<br>-Агентлагийн дарга нарын хуралд 4 удаа,<br>-ИТХ 1 удаа,<br>-“Эрүүл мэндийн технологи-2025 Үзэсгэлэн”,<br>-“Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн”,<br>-АЗДТГ-аас Агентлаг байгууллагын сонсголыг хэлэлцэх, ажил байдалтай танилцах хэлэлцүүлэг,<br>-Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Бүх нийтээр мод тарих” үндэсний өдрийн хүрээнд 1 удаагийн арга хэмжээнд оролцож хуваарыт газраа 24 ширхэг мод тарилаа. | 100 |
|-------|--|---|--|--|---|--|-----|

|       |   |   |  |   |  |  |     |
|-------|---|---|--|---|--|--|-----|
|       |   |   |  |   |  | <p>Орон нутгийн төсвөөс албан хаагчдын үндсэн цалингийн 20%-тай тэнцэх хэмжээний 1088,3 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг олгуулахаар үйл ажиллагааны тайланг хүргүүлсэн.</p> <p>Ажилтан албан хаагчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд Аймгийн ЗДТГ-тай хамтран “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан бичих арга зүй”, “Ёс зүйн зөрчил, бүртгэл хяналтын дэд системийг ашиглах аргачлал”, “Ёс зүйн хорооны ажиллах журам”, “Төрийн албаны шинэчлэгдэн гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг таниулах, мэдээлэл, арга зүйн удирдлагаар хангах”, “Зөрчлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт анхаарах асуудал” зэрэг сургалтад хамрагдсан.</p> <p><b>Үр дүн:</b> Аймаг орон нутгаас зохион байгуулсан 5 удаагийн сургалтад хамрагдсан.</p>   |     |
| 4.1.2 | Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо | Зохион байгуулсан арга хэмжээ-4, сургалтын тоо-15 | Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна. | <p>Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, орлого хамрагдалтыг нэмэгдүүлэх дараах сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээнд оролцлоо. Үүнд:</p> <p><b>Эрүүл мэндийн байгууллагуудад:</b></p> <p>Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд “Эрүүл мэндийн даатгалын шинэчлэл” сэдвээр</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гэрээт 23 эрүүл мэндийн байгууллагад ЭМДҮЗ-ийн 2025 оны 03, 04 дүгээр тогтоолын өөрчлөлтүүдийг танилцуулж, мэдээлэл зөвлөгөө, чиглэл өгөх сургалт;</li> <li>- МУ-ын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу хэрэгжиж буй “Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцаагчдад нүд, шүд, зүрхний эмгэгийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэй"-ийг орон нутагт зохион байгуулахтай холбогдуулан шүдний 11 хувийн эмнэлгийн эмч наарт мэдээлэл, олгох зэрэг сургалтуудыг тус тус зохион байгуулсан.</li> </ul> | 100 |

|       |  |   |   |  |  |  |     |
|-------|--|---|---|--|--|--|-----|
|       |  |   |   |  |  | <p>Түүнчлэн Дорноговь аймгийн эрүүл мэндийн газар нь Монголын сумын эмч мэргэжилтний холбоотой хамтран "Говийн бусийн сумын эмч, мэргэжилтний зэвлөгөөн"-ийг зохион байгуулж, 44 сумын эрүүл мэндийн төвийн 150 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан. Уг зэвлөгөөнд "Сумын эрүүл мэндийн төвийн хөгжлийн чиг хандлага, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам" сэдэвт хэлэлцүүлэгт оролцож ЭМД-тай холбоотой мэдээ, мэдээллээр хангасан.</p> <p><b>Иргэд олон нийтэд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- АЗДТГ-аас зохион байгуулсан агентлагийн удирдах албан хаагчдын сургалтад хамрагдаж ЭМДҮЗ-ийн 2025 оны тогтоолын шинэчлэл болон ЭМДС-ийн орлого хамрагдалт, зарцуулалтын талаар танилцууллаа.</li> <li>- Сайншанд сумын ЗДТГ-тай хамтран 7 багийн иргэдэд "Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, ач холбогдол" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.</li> </ul> <p>Мөн ЭМГ-тай хамтран "Эрүүл мэндийн технологи-2025" үзэсгэлэн өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж иргэд олон нийтийг ЭМД-тай холбоотой мэдээ, мэдээллээр хангасан. Нийт 8 удаагийн танхимиын сургалт, өдөрлөгийн арга хэмжээнд давхардсан тоогоор 133 байгууллага, 641 иргэд олон нийт мэдээллээр хангагдсан байна.</p> <p><b>Үр дүн:</b> Эрүүл мэндийн даатгалын хамралт нэмэгдсэн байна.</p> |     |
| 4.1.3 | Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн зохион хэмжээнд байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ. | - | Иргэд, даатгуулагчдаад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо | 2024 онд 4224 иргэн, даатгуулагчдаад мэдээ, мэдээллийг хүргэсэн. | 2025 онд 4300-аас доошгүй иргэн, даатгуулагчдаад эрүүл мэндийн даатгалын талаарх мэдлэг, | <p>Хэлтсийн албан ёсны цахим хаяг "Дорноговь аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтэс" нэртэй фейсбүүк хуудсыг тогтмол ажиллуулан, эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээ, мэдээллийг бэлтгэн хүргэж, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг И-баримт, И-Монголия аппликацийн ашиглан хэрхэн төлөх болон шалгах, E-Mongolia цахим системээр авсан тусламж үйлчилгээний мэдээллээ хэрхэн харах</p>  | 100 |

|       |  |   |                                    |   |   |   |     |
|-------|--|---|------------------------------------|---|---|---|-----|
|       |  |   |                                    |   | мэдээллийг хүргэсэн байна.  | <p>тухай сурталчилгаа, мэдээллийг 7 хоног бүр тогтмол 3-5 удаагийн давтамжтайгаар нийтэлж, орон нутгийн мэдээллийн нэгдсэн группууддэд түгээн, давхардсан тоогоор 2700 иргэн, даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн байна. Фейсбүүк хуудасны дагачдын тоог 552-д хүргэж, 238-р нэмэгдүүлсэн боловч энэхүү цахим хаяг устаж “Дорноговь аймаг-Эрүүл мэндийн даатгалын хэлтэс” фейсбүүк цахим хуудсыг шинээр нээн иргэд даатгуулагчдыг мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>Түүнчлэн тайлант хугацаанд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын цахим хуудсанд нийтлэгдсэн мэдээ, мэдээллийг шуурхай түгээж даатгуулагч иргэдийг тогтмол мэдээллээр ханган нийт 450 зурагт постер, 58удаагийн хөдөлгөөнт постер хэлбэрээр хүргэсэн байна.</p> <p>-Лавлах утсанд ирсэн 333 дуудлага, биечлэн ирсэн 263 нийт 596 даатгуулагч, иргэдийг зөвлөгөө мэдээллээр ханган эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт болон ЭМБ-ын үзүүлж буй тусламж үйлчилгээ, хэрэгжүүлж буй хууль тогтоомжийн талаарх мэдээллийг олгосон.</p> <p><b>Үр дүн:</b> Эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээ, мэдээллийг давхардсан тоогоор 3246 орчим иргэн, даатгуулагчид хүргэсэн байна.</p> |     |
| 4.1.4 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.10 Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ. | - | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо | 322 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. | Сэтгэл ханамжийн судалгаа авч, хэрэгжүүлсэн арга хэмжээний нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | <p>“ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ-2025” үзэсгэлэнг ЭМГ-тай хамтран Дорноговь аймагт хоёр дахь удаагаа амжилттай зохион байгуулсан. Тус үзэсгэлэнд төр ба хувийн хэвшлийн 60 гаруй эрүүл мэндийн байгууллагууд оролцож, орон нутагт шинээр нэвтрүүлсэн шинэ технологи, шилдэг туршлага, оношилгоо эмчилгээний давуу тал, чадавхаа танилцуулан орон нутгийн төр болон төрийн бус байгууллагын 20 гаруй албан газар, аж ахуйн нэгж, байгууллага, 300 гаруй иргэдэд үзлэг, оношилгоо хийж, зөвлөгөө мэдээллээр хангагдсан. Уг арга хэмжээний үеэр иргэд олон нийтэд Эрүүл мэндийн даатгалын ач</p>  | 100 |

|             |   |          |  |  |  | холбогдол, эруул мэндийн даатгалын хувь хэмжээг танилцуулан, 100 гаруй иргэдийг зөвлөгөө, мэдээллээр ханганд, сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан.<br>Мөн олон нийттэй харилцах хэлтсээс зохион байгуулж байгаа ЭМДЕГ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 06 дугаар удирдамжаар баталсан байгууллагын үйл ажиллагааг үнэлэх сэтгэл ханамжийн судалгаанд гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг идэвхтэй хамруулж, зохион байгуулалтыг хийж ажилласан. Уг судалгаанд тайлант хугацаанд 132 албан хаагч хамрагдсан байна.<br><b>Үр дүн:</b> Сэтгэл ханамжийн судалгаанд нийт 232 даатгуулагч иргэн, гэрээт эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд хамрагдсан байна.   |      |          |          |       |         |           |           |     |    |     |     |    |    |    |             |     |     |     |     |     |     |     |
|-------------|---|----------|--|--|--|--|------|----------|----------|-------|---------|-----------|-----------|-----|----|-----|-----|----|----|----|-------------|-----|-----|-----|-----|-----|-----|-----|
| 4.1.5       | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.15 Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана. | -        | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | Албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийн тоо 12 шийдвэрлэлт 100 хувь. | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг өрөнхий газарт хүргүүлсэн байна. | Тайлант хугацаанд 596 иргэнд дараах хэлбэрээр үйлчилгээ үзүүлсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>• Цахимаар -11</li><li>• Лавлах утсаар -333</li><li>• Биечлэн уулзах – 252г.м.</li></ul> Мөн ЭМД-ын шимтгэл төлөхдөө и-баримт аппликашнээр давхардуулж төлсөн 38 өргөдлийг бичгээр гаргасныг хүлээн авч, ЭМДЕГ-ын <a href="mailto:info@emd.gov.mn">info@emd.gov.mn</a> цахим хаягаар холбогдох албан тушаалтанд шилжүүлж, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлсэн.<br>Шийдвэрлээгүй өргөдөл, гомдол, хүсэлт байхгүй байна.<br>Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт: <table border="1"><thead><tr><th>Нэгж</th><th>Ирээн ДБ</th><th>Явсан ДБ</th><th>Санал</th><th>Өргөдөл</th><th>Ирээн ДАБ</th><th>Явсан ДАБ</th></tr></thead><tbody><tr><td>Тоо</td><td>65</td><td>100</td><td>648</td><td>12</td><td>22</td><td>16</td></tr><tr><td>Шийдвэрлэлт</td><td>100</td><td>100</td><td>100</td><td>100</td><td>100</td><td>100</td></tr></tbody></table> | Нэгж | Ирээн ДБ | Явсан ДБ | Санал | Өргөдөл | Ирээн ДАБ | Явсан ДАБ | Тоо | 65 | 100 | 648 | 12 | 22 | 16 | Шийдвэрлэлт | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 |
| Нэгж        | Ирээн ДБ  | Явсан ДБ | Санал  | Өргөдөл  | Ирээн ДАБ  | Явсан ДАБ  |      |          |          |       |         |           |           |     |    |     |     |    |    |    |             |     |     |     |     |     |     |     |
| Тоо         | 65  | 100      | 648  | 12   | 22   | 16   |      |          |          |       |         |           |           |     |    |     |     |    |    |    |             |     |     |     |     |     |     |     |
| Шийдвэрлэлт | 100   | 100      | 100  | 100  | 100  | 100  |      |          |          |       |         |           |           |     |    |     |     |    |    |    |             |     |     |     |     |     |     |     |

|       |   |   |   |   |  |  |     |
|-------|---|---|---|---|--|--|-----|
|       |   |   |   |   |  | Ирсэн, явсан баримт бичгийн шийдвэрлэлтийн биелэлтийг хугацаанд нь ирүүлэх болон явуулах ажлыг зохион байгуулж, явцын байдалд байнгын хяналт тавин ажилласан.  |     |
| 4.1.6 | Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана               | - | Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | ЭМДЕГ-ын удирдлагуудын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 32 удаа гаргаж хэрэгжилт 100 хувь. | Удирдах дээд газраас өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | ЭМДЕГ-ын шуурхай хуралд долоо хоног бүр оролцон, шинэ мэдээ мэдээллийг хэлтсийн мэргэжилтэнд хүргэж, өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэн ажилладаг. Шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 16 удаа үнэн зөвөөр тайлагнаж, хугацаанд нь хүргүүлсэн. | 100 |
| 4.1.7 | Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана | - | Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | Даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн биелэлтийн хангаж тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн.                        | Удирдах дээд газраас өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | ЭМДЕГ-ын нэгжийн удирдлагын зүгээс өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр нь хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>-АЗДТГ-ын удирдлагаас өгөгдсөн 2 удаагийн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнан ажилласан.          | 100 |

|       |   |   |   |  |  |   |     |
|-------|---|---|---|--|--|---|-----|
| 4.1.8 | <p>Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</p> | - | <p>Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, ГТ-ний биелэлтийн хувь</p> | <p>Хэлтсийн мэргэжилтэнгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан</p>             | <p>Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна.</p> | <p>-ЭМДЕГ-ын даргатай байгуулсан гэрээг үндэслэн хэлтсийн албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулж, ажлын байрны тодорхойлолт болон төлөвлөгөөнд тусгагдсан үүрэгт ажлуудыг хуваарийн дагуу хугацаанд нь биелэлтийг хангуулахад анхаарч, өдөр тутмын удирдлагаар ханган зөвлөн тусалж, чиглүүлэн, холбогдох дүрэм, журмыг албан хаагчдад байнга танилцуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан.<br/>-Хэлтсийн мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөг хагас жилийн байдлаар дүгнэн ЭМДЕГ-т хүргүүлсэн.</p> | 100 |
| 4.1.9 | <p>Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.</p>  | - | <p>Архивын нэгжийн тоо (боть)</p>   | <p>2023-2024 оны 89 архивын нэгжийг бүрдүүлж, албан бичиг хөтлөлтийн анхан шатны баримтуудыг цэгцлэн ЭМДЕГ-ийн архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн.</p> | <p>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу архивын нэгжийг бүрдүүлсэн байна.</p>                   | <p>-Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хүрээнд хэлтсийн хөтлөх хэргийн нээсний жагсаалтын дагуу 2024 оны ЭМД-ын сангийн зарлагын анхан шатны баримтууд, ирсэн явсан бичиг, тайлан мэдээ, гэрээ дүгнүүлэхээр ирүүлсэн материалуудыг цэгцлэн архивын 49 нэгж үүсгэн ЭМДЕГ-т хүргүүлсэн.</p>   | 100 |

|            |  |   |  |  |   |  |     |
|------------|--|---|--|--|---|--|-----|
| 4.1.1<br>0 | Цахим гарын үсгийг үйл бүрэн ажиллагаанд нэвтрүүлнэ.   | - | Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо                              | -  | Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд цахим гарын үсгийг бүрэн нэвтрүүлсэн байна. | Мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд цахим гарын үсгийг бүрэн нэвтрүүлсэн. Тайлант хугацаанд нийт 2 удаагийн албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан холбогдох иргэн, байгууллагуудад хүргүүлсэн.                                | 100 |
| 4.1.1<br>1 | Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна. | - | -Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо,<br><br>- Хэрэгжилтийн хувь | -  | Албан хэрэг хөтлөлтийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна.       | Төрийн албан бичгийг хос бичгээр хөтлөн явуулах хуулийн дагуу албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөн 1 удаа гаргасан.   | 100 |
| 4.1.1<br>2 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана   | - | Хэрэгжилтийн хувь  | Хуулийн хугацаанд ХАСХОМ, ХАСУМ-ээ 100 хувь мэдүүлсэн байна. | Хэрэгжилтийг ханган ажилласан байна.  | АТГ-аас зохион байгуулсан "ХАСХОМ-ийн маягтад орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар мэдээлэл олгох сургалтад хэлтсийн албан хаагчдыг бүрэн хамруулж мэдээллээр хангасан. ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд хэлтсийн албан хаагчид мэдүүлж, ЭМДЕГ-ын холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн ажилласан. | 100 |

|     |   |   |   |   |  |   |     |
|-----|---|---|---|---|--|---|-----|
| 5.1 | Эрүүл мэндийн даатгалын шинэчлэгдсэн тогтоол шийдвэрүүдийг тухай бүр нь судалж, танилцан бүрэн мэдлэгтэй болно.   | - | Шинэчлэгдсэн тогтоол, шийдвэрүүдийг бүрэн судалсан эсэх |   | Сургалтад бүрэн хамрагдсан байна.  | БТГ-аас зохион байгуулсан ЭМДҮЗ-ийн 2023 оны 10 дугаар тогтоол, 2024 оны 04, 05 дугаар тогтоолыг шинэчлэн баталсан тогтоолын танилцуулга, сургалтад хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдсан.  | 100 |
| 5.2 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.4 ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана.                   | - | Хамрагдсан сургалтын тоо                                | ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдсан. | ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах нийт сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг, мэдээлэл авсан байна. | ЭМДЕГ-ын 2025 оны баталсан сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулгаждаж буй сургалтад хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдаж мэдлэг чадвараа ахиулан ажиллаж байна.   | 100 |
| 5.3 | Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал, хувь хүний хөгжлийн чиглэлээр танхимын болон онлайн сургалтуудад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ. | - | Хамрагдсан сургалтын тоо                                | Нийт удаагийн сургалтад оролцсон.                         | Сургалт, семинарт бүрэн хамрагдсан байна.<br>23  | Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гаригт зохион байгуулдаг "Вебинар" цахим сургалтад 6 удаа хамрагдсан.<br>ЭМДЕГ-ын газар хэлтсээс зохион байгуулсан "Мэдээллийн цаг хөтөлбөр"-ийн 5 удаагийн сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулсан. "Хувь хүний хөгжил", "Төрийн албан хаагчийн ёс зүйн удирдлагын манлайлал" сэдвээр АЗДТГ-аас зохион байгуулсан сургалтад хамрагдсан.<br>Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албаны зөвлөлөөс гарсан шинэчлэгдсэн тогтоол, шийдвэр"-ийг танилцуулах онлайн сургалтад хэлтсийн албан хаагчдыг бүрэн хамруулж мэдлэг, мэдээллийг ахиулсан.<br><b>Хамрагдсан сургалтын тоо: 13</b> | 100 |

|     |   |   |                          |   |   |   |     |
|-----|---|---|--------------------------|---|---|---|-----|
| 5.4 | Монгол бичгийн мэдлэг, чадварын түвшинг ахиулах сургалтад хамрагдах | - | Хамрагдсан сургалтын тоо | - | Албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадвар дээшилж, Монгол бичгийн хэрэглээний орчин сайжирсан байна. | Хэлтсийн албан хаагчдыг ЭМДЕГ-аас зохион байгуулж буй үндэсний бичгийн мэдлэг, чадвар дээшлүүлэх монгол бичгийн сургалтад цахимаар хамруулсан.<br>Мөн аймгийн "Насан туршийн суралцахуйн төв"-д монгол бичгийн 2 сарын сургалтад хамрагдаж, монгол бичгээр уншиж, бичиж, албан бичиг хөтлөх ур чадварт суралцаж байна.<br><b>Хамрагдсан сургалтын тоо-2</b> | 100 |
|-----|---|---|--------------------------|---|---|---|-----|

Төлөвлөгөөг үнэлсэн:


ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ  
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

Тайлгнасан:

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Төсвийн шууд захирагч

/ С.ЭНХБОЛД /

Нэгжийн дарга

/ Б.ОЮУНЦЭЦЭГ /

2025-06-24

Нэгжийн дарга

/ Х.ЛХАГВАЖАРГАЛ /

2025-05-19